


## Цахилгааныг аюулгүй бөгөөд ухаалгаар ашиглах

### Урьдчилан бэлдэж сэргийлцгээе!



**Хэлхээ таслагчийг шалгах!**  
Сар бүр 1удаа тест товчлуурыг дарж хэвийн ажиллаж буй эсэхийг шалгах хэрэгтэй.

\*Хэлхээ таслагч ажиллахгүй байх, түлэнхий үнэртэх тохиолдолд төхөөрөмжийг солих хэрэгтэй.



**Тоостой залгуур!**  
Цахилгааныг унтраасны дараа цэвэрлэх хэрэгтэй.



**Шалбарсан цахилгаан утас!**  
Шалбарсан цахилгаан утас аюултай учраас тэр даруй солих хэрэгтэй.

### Эрчим хүч хэмнэх арга!



**Эрчим хүчний хэмнэлт**  
1-р зэрэглэлийн бүтээгдэхүүнийг ашиглаж цахилгаан хэмнэе.



**Хөргөгчний багтаамжийг 60%-иас**  
хэтрэхгүй дүүргэж эрчим хүчний хэмнэлтийг ихэсгэе.



**Хүйтэн усаар угаалга хийж**  
эрчим хүчийг хэмнэе.



БНСУ-ын цахилгааны аюулгүй ажиллагааны корпорац нь орон сууц гм байрны цахилгаан төхөөрөмжийн аюулгүй байдлыг 1-3жил тутам үнэ төлбөргүйгээр шалгаж байдаг.

## Цахилгааны аюулгүй байдлыг лавлах

Цахилгааны аюулгүй ажиллагааны дуудлагын төв

(+82) 1588-7500



Цахилгааны аюулгүй байдлыг эндээс

<http://safety.kesco.or.kr>

\* Манай гэрийн аюулгүй байдлыг шалгах эсэх, шалгасан байдлын хариу гм талаар мэдэх боломжтой.




Цахилгааныг аюулгүй бөгөөд ухаалгаар ашиглах дүрэм!

몽골어

Цахилгааныг аюулгүй байдлаар ашиглах танилцуулга

# Цаг тухай бүрт цахилгаан ашиглах аюулгүй арга



# Өөрөө хянах цахилгааны аюулгүйн шалгуур



## Бидний амьдралд заавал хэрэглэгдэх цахилгаан!

Сайн ойлгож хэрэглэвэл таны амьдрал гэрэл гэгээтэй байх боловч, мэдэхгүйгээр хэрэглэвэл таны ирээдүйг харанхуй болгох магадлалтай юм.

### Зуны улирал



#### Борооны улиралд ус тогтоолсон гэрлэн дохио, ус зайлуулагчийн тагнаас болгоомжлох хэрэгтэй.

Борооны ус тогтоолсон гэрлэн дохио, ус зайлуулагч цахилгаан дамжуулах магадлалтай



#### Чийг татагчийн ойролцоо угаасан зүйлээ хатааж болохгүй.

Угаасан зүйлээс ус дуссанаас болж цахилгаан дамжих магадлалтай.

### Намрын улирал



#### Чийгшүүлэгчийг залгуур болон цахилгаан төхөөрөмжөөс хол байлгах хэрэгтэй.

Чийгшүүлэгчийн уур залгуур болон цахилгаан төхөөрөмжинд хүрснээс цахилгаан холбоо үүсэх аюул ихэсдэг.



#### Халдаг гүдсыг эвхэж хэрэглэж болохгүй.

Халдаг гүдсыг эвхэж хэрэглэвэл доторх цахилгаан утас нь орооцолдож цахилгаан холбоо үүсэх аюултай

## Сар бүрийн 4нд цахилгааны аюулгүй байдлыг шалгах өдөр!

Цахилгааныг аюулгүйгээр ашиглаж буй эсэхээ өөрөө шалгаж үзээрэй.

## CHECK LIST

### Гэрийн нөхцөлд

|   | тийм                     | үгүй                     |
|---|--------------------------|--------------------------|
| 1. Хэлхээ таслагчийн тест товчлуурыг дарахад хэвийн ажиллаж байсан. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 2. Залгуурыг нэг дор олноор залгаж хэрэглэдэггүй.                   | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 3. Залгуурын нүх хооронд тоос байхгүй байна.                        | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 4. Цахилгаан халаагчийн ойролцоо шатамхай зүйл байхгүй.             | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 5. Хэрэглэхгүй байгаа залгуурт аюулгүйн таг хэрэглэж хаасан.        | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

### Ажлын байранд

|   | тийм                     | үгүй                     |
|---|--------------------------|--------------------------|
| 1. Цахилгаантай ажиллах үедээ хамгаалалтын хувцас өмсөнө.                 | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 2. Цахилгаан самбарын ойролцоо ямар нэг зүйл байхгүй.                     | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 3. Цахилгаан төхөөрөмжийн ойролцоо шатамхай зүйлс байхгүй.                | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 4. Цахилгаан төхөөрөмж KS, KC гм батламж марктай бүтээгдэхүүн хэрэглэдэг. | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 5. Цахилгаан төхөөрөмжийн утас элэгдээгүй байна.                          | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

“  ” бол зөв ашигласан арга юм.

“  ” тэмдэглэгээ байгаа бол залруулж аюулгүй байдлаар ашиглана уу.